



**ТАВАНТОЛГОЙ ХК**

**“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 21/01

Тавантолгой

**“Тавантолгой” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайланг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.13 дэх заалт, Тооллогын комиссын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 2021/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр гаргасан санал дүгнэлтийг 2021 оны үйл ажиллагааны бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ТҮВШИНБАЯР



**“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 21/02

Тавантолгой

**“Тавантолгой” ХК-ийн 2020 оны үйл  
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх  
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.9 дэх заалт, Тооллогын комиссын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 2021/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг цаашид бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ж.Доржсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ТҮВШИНБАЯР



**“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 21/03

Тавантолгой

**Ногдол ашиг хуваарилах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.13 дэх заалт, Тооллогын комиссын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 2021/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас ногдол ашиг болгон нэгж хувьцаанд 535 / таван зуун гучин таван / төгрөгөөр тооцож хуваарилахаар тогтоосугай.
2. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Ж.Доржсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ТҮВШИНБАЯР



ТАВАНТОЛГОЙ ХК

“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 21/04

Тавантолгой

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.7 дэх заалт, Тооллогын комиссын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 2021/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

- 1.1. Ц.Даваацэрэн / ердийн гишүүн /
- 1.2. Ш.Баянбат / ердийн гишүүн /
- 1.3. Г.Цог-Өрнөх / ердийн гишүүн /
- 1.4. Д.Дагвадорж / ердийн гишүүн /
- 1.5. Г.Ганчимэг / ердийн гишүүн /
- 1.6. С.Мөнхжаргал / ердийн гишүүн /
- 1.7. Б.Түвшинбаяр / хараат бус гишүүн /
- 1.8. Д.Нацагдорж / хараат бус гишүүн
- 1.9. Т.Тэгшээ / хараат бус гишүүн /

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн ажиллуулахаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ТҮВШИНБАЯР